



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Засгийн газрын автобааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 33,329,000.00 (гучин гурван сая гурван зуун хорин есөн мянга) төгрөгийн балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасч, орон нутгийн өмчид (Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газарт) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.“Засгийн газрын автобааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Чинзориг, Өвөрхангай аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ц.Ганболд наарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132001275
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 27.-ны өдрийн
/3.0 дугаар тогтоорлын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРЭЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГОД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАЖ, ОВОРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ БҮРТГЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашины марк, улсын дугаар арлын дугаар	Үйлдвэрлэсэн/аш иглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хьюндай Соната-УФ, 05-78 УАК, КМНЕВ41BACA412972	2012/2012	33,329,000.00	33,329,000.00	33,329,000.00
	НИЙТ ДҮН		33,329,000.00 (гучин гурван сая гурван зуун хорин есөн мянган)	33,329,000.00 (гучин гурван сая гурван зуун хорин есөн мянган)	